



## НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/Б25

Улаанбаатар хот

### Шийдвэр хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн Гуравдугаар бүлгийн 3.2 дугаар зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 Эрүүл мэндийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн яам төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 2/1126 дугаартай чиглэл, газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн тусгай зөвшөөрлийн комиссын 2024 оны 04 дүгээр хурлын шийдвэрээр эмийн сангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх ажлын байр нь "Орон сууцны зориулалттай" үл хөдлөхийн гэрчилгээтэй тохиолдолд тусгай зөвшөөрөл шинээр олгохгүй болон хаягийн өөрчлөлт хийхээс татгалзах шийдвэрийг хүчингүй болгож, "Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага" MNS 5260:2015 стандартад нийцүүлсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллийг хувийн хэвшлийн байгууллагуудад түгээн ажиллахыг Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БАТЦООЖ

